



МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 06


Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.9.12 дахь заалт, 48.10 дахь хэсэг, 53 дугаар зүйлийн 53.2 дахь хэсэг, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 4.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн Хуульчдын холбооны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Монголын Хуульчдын холбооны "Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тооцох журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ журам батлагдсантай холбогдуулан Монголын Хуульчдын холбооны Удирдах зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн хурлын 27 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тооцох журам"-ыг хүчингүй болгосугай.
3. Энэ тогтоолыг 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ



П.ОДГЭРЭЛ

Сүлд



**ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ,
БАГЦ ЦАГ ТООЦОХ ЖУРАМ**

Монголын Хуульчдын холбооны
зөвлөлийн 2023 оны 03 дугаар
сарын 25-ний өдрийн хурлын 0.6
дугаар тогтоолын хавсралт

**ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ,
БАГЦ ЦАГ ТООЦОХ ЖУРАМ**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 дүгээр зүйл. Ерөнхий зүйл

1. Энэ журмаар Монголын Хуульчдын холбоо /цаашид "Холбоо" гэх/-оос хуульчийн үргэлжилсэн сургалт /цаашид "үргэлжилсэн сургалт" гэх/ зохион байгуулах, түүнд хяналт тавих, үргэлжилсэн сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, сургалтын багц цаг тооцох болон үргэлжилсэн сургалтад хамрагдах хуульчийн үүргийг хангуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

2. Үргэлжилсэн сургалтын зорилго нь хуульчдын мэдлэг, мэргэшлийн түвшин, ур чадварыг эрх зүйн онолын орчин үеийн чиг хандлага, эрх зүйн шинэтгэл, шүүх эрх мэдлийн байгууллагын хөгжлийн шаардлагад нийцүүлэн тогтмол дээшлүүлэх, мэргэжлийн ёс зүйг чанд мөрдөж, шударга, хараат бусаар ажиллах чадварыг төлөвшүүлэхэд чиглэнэ.

3. Үргэлжилсэн сургалт нь Суурь сургалт, Мэргэшүүлэх сургалт, Практик сургалт гэсэн төрөлтэй байна.

4. Хуульч нь шүүн таслах ажиллагаанд оролцох, хууль зүйн зөвлөгөө өгөх ажил, үүргээ мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж, хэрэгжүүлэх, мэргэжлийн мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлэх, хуульчийн нэр хүнд, мэргэжлийн хариуцлагыг ямагт өргөж байхын тулд үргэлжилсэн сургалтад тогтмол хамрагдаж, жил тутам энэ журамд заасан хэмжээний багц цагийн сургалтад хамрагдах үүрэг хүлээнэ.

1.2 дугаар зүйл. Нэр томъёоны тайлбар

1. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1. "Үргэлжилсэн сургалт" гэж энэхүү журмын 1.1 дүгээр зүйлийн 2-т заасан зорилгод нийцсэн сургалтын хорооноос магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн дагуу тухайн жилд үргэлжлэн явагдах сургалтыг;

1.2.2. "Нөхөн сургалт" гэж тухайн жилийн үргэлжилсэн сургалтад хамрагдах үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй хуульчдад зориулсан сургалтыг;

1.2.3. Суурь сургалт гэж хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн, хууль зүйн шинжлэх ухааны мэдлэг, арга зүйг бататгах, гүнзгийрүүлэх, хуульчийн практик үйл ажиллагаанд шаардлагатай мэдлэг, чадварыг олгоход чиглэсэн сургалтыг ойлгоно.

1.2.4. Мэргэшүүлэх сургалт гэж тухайн салбар эрх зүйн чиглэлээр дагнан ажиллах мэдлэг ур чадвар олгох, хууль хэрэглээний чиглэлээр зохион байгуулж байгаа зорилтод сургалтыг ойлгоно.

1.2.5.“Практик сургалт” гэж аудио, видео сургалт, нийтийн ашиг сонирхлын төлөө тодорхой асуудлыг шийдвэрлэх хүрээнд дүн шинжилгээ хийх, үр дүнг хэлэлцүүлэх, түүнчлэн хүний эрхийг хамгаалах, хууль тогтоомжийн хэрэглээний талаар суурь болон хавсарга судалгаа хийх, эрдэм шинжилгээний өгүүлэл, нэг сэдэвт бүтээл, гарын авлага гаргах, хууль боловсруулах ажлын хэсэгт оролцох, хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх, хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд албан ёсны болон сайн дурын санал боловсруулах үйл ажиллагааг ойлгоно.

1.2.6.“Шинжээч” гэж шинжлэх ухааны тодорхой салбарын болон практикийн бодит байдлыг тогтооход шаардлагатай тусгай мэдлэг, дадлага, туршлага эзэмшсэн, тухайн асуудлаар шинжилгээ хийх, тусгай мэдлэгийн хүрээнд өөрийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах, түүнийхээ төлөө хариуцлага хүлээх чадвартай этгээд;

1.2.7.“Багц цаг” гэж үргэлжилсэн сургалтын хөтөлбөрийг тодорхой тооны цагаар багцалсныг;

1.2.8.“Багц цаг хангах” гэдэгт хуульч энэ журамд заасан доод хэмжээнээс багагүй багц цагийн үргэлжилсэн сургалтад хамрагдсан байхыг тус тус ойлгоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН ТӨРӨЛ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1 дүгээр зүйл. Суурь сургалтын хөтөлбөрийн агуулга, тавигдах шаардлага

1. Суурь сургалтын хөтөлбөр нь хуульчдын суурь мэдлэг, ур чадварыг орчин цагийн хөгжлийн шаардлагад нийцүүлэх, тогтмол дээшлүүлэх, хараат бусаар ажиллах мэдлэг, чадварыг хангах, тодорхой үе шат, дараалалтай, уялдаа холбоотой боловсруулсан агуулгатай байна.

2. Суурь сургалтын хөтөлбөр нь хууль зүйн шинжлэх ухаан, бусад шинжлэх ухааны сэдвийг агуулсан байна.

2.1.Хууль зүйн шинжлэх ухаан

2.1.1.Үндсэн хуулийн эрх зүй

2.1.2.Олон Улсын эрх зүй /ОУ-ын гэрээ, конвенц, пакт/

2.1.3.Хүний эрх

2.1.4.Хуульчийн ёс зүй

2.2.Бусад шинжлэх ухаан

3.Үндсэн хуулийн эрх зүйн хичээл нь Үндсэн хуулийн эрх зүйн үндсэн ойлголт, түүнчлэн улс төр, ардчилал, иргэний нийгэм, хүний үндсэн эрхийн ойлголт, практик, Үндсэн хуулийн цэц, түүний чиг үүрэг, Цэцээс гаргасан шийдвэрт дүн шинжилгээ хийх, процесс ажиллагаа, хууль хэрэглээний асуудлыг хөндсөн байна.

4.Олон улсын гэрээ, конвенц, пактын хичээл нь Олон улсын гэрээ, конвенц, пактын ойлголт, түүний механизм, Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, конвенц, хүлээсэн үүрэг, хариуцлага, Олон улсын гэрээ, баримтыг судлах, хууль хэрэглээ, шүүхийн практикт хэрэглэх арга зүй, ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэнэ.

5.Хүний эрхийн хичээл нь хүний эрхийн ойлголтын талаар мэдлэг, хүний үндсэн эрхийг хангах, хүний эрхийг хамгаалахад хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр гаргахад хүний эрхийг асуудлыг тусгах, дүгнэлт хийх, ур чадвар эзэмшүүлэхэд чиглэнэ.

6. Хуульчийн ёс зүйн хичээл нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг чанартай, хариуцлагатай байлгах, мэргэжлийн дүрмийг хэрэгжүүлэх арга барил, хуульчийн ёс зүйг төлөвшүүлэхэд чиглэнэ.

7. Бусад шинжлэх ухааны сургалт нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд шаардлагатай бусад шинжлэх ухааны мэдлэгийг олгох, ур чадвар эзэмшүүлэхэд чиглэнэ.

8. Суурь сургалтын хөтөлбөр тухайн жилийн үргэлжилсэн сургалтын хөтөлбөрт заавал байх бөгөөд 2 жилийн хугацаатайгаар төлөвлөн боловсруулна.

2.2 дугаар зүйл. Суурь сургалт заах сургагч багшид тавигдах шаардлага

1. Суурь сургалтын хичээлийг заах сургагч багш магистр, түүнээс дээш зэрэгтэй, сургалт явуулах ажлын туршлагатай байна.

2. Суурь сургалтын хичээл заах сургагч багшийг Сургалтын хороо сонгон шалгаруулна.

3. Сургагч багш онолын мэдлэг, заах арга зүй, ур чадвараа байнга дээшлүүлэх үүрэгтэй.

2.3 дугаар зүйл. Практик сургалтын агуулга, тавигдах шаардлага

1. Практик сургалт нь хуульчдын мэдлэг, ур чадварыг орчин цагийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх, хуульчдыг чадавхжуулахад чиглэгдсэн агуулгатай байна.

2. Практик сургалт нь тодорхой асуудлыг шийдвэрлэх хүрээнд судалгаа, дүн шинжилгээ хийх, төсөл хэрэгжүүлэх, стратегийн өмгөөлөл явуулах, хууль тогтоомж боловсруулах үйл ажиллагаанд оролцохыг дэмжихэд чиглэгдэнэ.

2.1. Аудио, видео сургалт нь практик сургалтын төрөлд хамаарна.

2.2. Эрдэм шинжилгээний өгүүлэл, нэг сэдэвт бүтээл, гарын авлага нь практик сургалтын төрөлд хамаарна.

2.3. Мэргэжлийн чиглэлээр төсөл хөтөлбөрт хамрагдах, хууль тогтоомж боловсруулах ажлын хэсэгт ажилласан, стратегийн өмгөөлөл явуулсан бол практик сургалтын төрөлд тооцогдоно.

2.4. Монголын хуульчдын холбооны цахим хуудсаар хууль хэрэглээний талаар санал дэвшүүлж, тухайн санал нь хуульчдын дунд зохион байгуулагдсан хэлэлцүүлгээр хэлэлцэгдсэн бол практик сургалтын төрөлд тооцогдоно

2.4 дүгээр зүйл. Практик сургалт явуулах багшид тавигдах шаардлага

1. Видео, аудио сургалтыг явуулах сургагч багш магистр, түүнээс дээш зэрэгтэй, сургалт явуулах ажлын туршлагатай байна.

2. Видео, аудио сургалтыг явуулах сургагч багшийг Сургалтын хороо сонгон шалгаруулна.

3. Сургагч багш онолын мэдлэг, заах арга зүй, ур чадвараа байнга дээшлүүлэх үүрэгтэй.

2.5 дугаар зүйл. Мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн агуулга, тавигдах шаардлага

1. Мэргэшүүлэх сургалт нь тухайн салбар эрх зүйн чиглэлээр дагнан ажиллах зорилгын хүрээнд онол, практикийн цэгцтэй мэдлэг олгох, тодорхой тохиолдлыг задлан шинжлэх, хууль зүйн дүн шинжилгээ хийх чадварыг дээшлүүлэх, хууль тогтоомжийн өөрчлөлт шинэчлэлттэй уялдсан шинэлэг зохицуулалтыг практикт хэрэглэх аргачлал, мэдлэг олгоход чиглэгдэнэ.

2. Мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн агуулга нь салбар эрх зүйн хоорондын болон бусад салбар шинжлэх ухаан хоорондын шинжтэй мөн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг олгох, харилцаа хандлагыг хөгжүүлэхэд чиглэгдэж болно.

3. Салбар эрх зүйн чиглэлээр мэргэшсэн байгууллага сургалтын хөтөлбөрөө Сургалтын хороогоор магадлан итгэмжлүүлсний үндсэн дээр мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж болно.

4. Мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр тухайн жилийн үргэлжилсэн сургалтын хөтөлбөрт заавал байх бөгөөд 2 жилийн хугацаатайгаар төлөвлөн боловсруулна.

5. Мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах давтамжийн хугацаа нь жилд 4-6 удаа байна.

2.6 дугаар зүйл. Мэргэшүүлэх сургалт явуулах байгууллага, сургагч багшид тавигдах шаардлага.

1. Мэргэшүүлэх сургалтыг явуулах багш нь тухайн салбар эрх зүйн өндөр ур чадвартай, магистраас дээш зэрэг, цолтой, сургалт явуулах ажлын туршлагатай байна.

2. Тухайн чиглэлээр мэргэшсэн байгууллага, хуулийн этгээд мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулна.

3. Мэргэшүүлэх сургалтын төрөлд салбар эрх зүйн чиглэлээр бэлтгэсэн “Үндсэн лекц” орох бөгөөд жил бүр 4-өөс дээш “Үндсэн лекц”-ийг хуульчид сонгон суралцана.

4. Үндсэн лекц нь танхим болон видео хэлбэртэй байна.

5. Үндсэн лекц нь хуульчдын онолын мэдлэг, хууль хэрэглээний чадварыг олон улсын түвшинд хүргэх, Үндсэн хууль, Эрүүгийн эрх зүй, Иргэний эрх зүй, Захиргааны эрх зүйн салбарт хууль хэрэглээний нэгдмэл байдлыг бий болгох зорилгоор бэлтгэгдсэн байна.

6. Үндсэн лекцийн хөтөлбөрийг Сургалтын хороогоор магадлан итгэмжлүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН БАГЦ ЦАГ, ТҮҮНИЙГ ТООЦОХ

3.1 дүгээр зүйл. Сургалтын багц цаг

1. Хуульч жил бүр 4-өөс доошгүй багц цагийн сургалтад хамрагдсан байх бөгөөд 1-ээс доошгүй багц цаг нь суурь болон практик сургалт, 1 багц цаг нь мэргэшүүлэх чиглэлийн сургалт байна.

2. Шинэ хуульч нь зөвшөөрөл олгогдсоноос хойш эхний нэг жилд 6-аас доошгүй багц цагийн сургалтад хамрагдах бөгөөд үүнээс 4-өөс доошгүй багц цагийг танхимын сургалтаар, үлдсэнийг нь танхимын бус сургалтаар хангаж болно.

3. Сургалтын 8 цагийн хичээлийг үргэлжилсэн сургалтын 1 багц цагт тооцно. Нэг цагийн хичээлийн үргэлжлэх хугацаа 45 минут байна. Аудио, видео хичээлийн үргэлжлэх хугацаа 30 минут байна.

4. Үргэлжилсэн сургалтын багц цагийг сургалтын болон сургалтын бус хэлбэрээр хангаж болно. Сургалтын хэлбэр нь танхимын болон танхимын бус байх бөгөөд танхимын бус сургалтыг зайны /вебинар/, аудио, видео хичээлийн хэлбэрээр явуулна. Танхимын бус сургалтаар хангах багц цаг нь тухайн жилд хангах нийт багц цагийн 50 хувиас хэтрэхгүй байна.

5. Суурь болон мэргэшүүлэх сургалтыг цахим хэлбэрээр явуулж болно.

5.1. цахим сургалтад хамрагдсан бол энэ зүйлийн 2-т заасан хэжээгээр;

5.2. үргэлжилсэн сургалтын хөтөлбөр боловсруулж магадлан итгэмжлүүлсэн бол 1 багц цаг;

5.3. үргэлжилсэн сургалтад хичээл заасан бол 4 цаг тутамд 0.5 багц цаг;

5.4. тухайн жилд хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан бол 1 багц цаг;

5.5. тухайн жилд хууль зүйн докторын (Ph.D) зэрэг хамгаалсан бол 4 багц цаг;

5.6. тухайн жилд хууль зүйн магистрын ажил удирдаж хамгаалуулсан бол 0,5 багц цаг, докторын (Ph.D) ажил удирдаж хамгаалуулсан бол 1 багц цаг;

5.7. хууль зүйн мэргэжлийн сэтгүүлд хууль, эрх зүйн чиглэлээр эрдэм шинжилгээний өгүүлэл, шүүмж бичиж нийтлүүлсэн бол тус бүр 1 багц цаг;

5.8. хууль зүйн мэргэжлийн сурах бичиг, нэг сэдэвт бүтээл, гарын авлага зохиож нийтлүүлсэн бол 4 хүртэлх багц цаг, хамтран зохиогч нарт багц цагийг хувь тэнцүүлэн тооцох;

5.9. Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт эрх бүхий этгээдийн шийдвэрээр томилогдон ажилласан, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журмын төслийг боловсруулж, тэр нь батлагдсан бол 0,5 багц цаг. Энэ нь тухайн хуульчийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэгт хамаарч байгаа бол энэ заалт үйлчлэхгүй;

5.10. хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаанд зарцуулсан 30 цагт болон нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг шүүхэд нэхэмжлэл гаргах замаар төлөөлөн хамгаалан шүүхээр шийдвэрлүүлсэн 1 хэрэгт 0,5 багц цаг тооцох;

5.11. Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл өгч, Үндсэн хууль зөрчигдсөн гэдгийг тогтоон маргаан үүсгэж амжилттай шийдвэрлүүлсэн 1 хэрэгт 0,5 багц цаг тооцох;

5.12. Хууль зүйн салбарын төсөл, судалгаанд оролцож судалгааны ажил, тайлан нь хэвлэгдсэн бол тус бүр 1 багц цаг;

5.13. хууль зүйн салбарын олон улсын болон улсын хэмжээний уралдаан, тэмцээн, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан, удирдсан, шүүгчээр ажилласан бол 1 багц цаг тооцох;

5.14. тухайн жилд Хуульчдын холбооны чиг үүргийн болон сайн дурын хороодоос зохион байгуулсан хууль эрх зүйн чиглэлийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон бол тухайн хорооны саналыг харгалзан 1 хүртэлх багц цаг тооцох;

5.15. тухайн жилд хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлсэн, хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд албан ёсны болон сайн дурын санал боловсруулах үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон бол холбогдох хорооны саналыг харгалзан 0,5 цаг тооцох;

5.16. Мэргэшүүлэх сургалтын “Үндсэн лекц” бэлтгэж, магадлан итгэмжлүүлсэн бол лекц тус бүрд 0,5 багц цаг тооцох;

5.17. тухайн жилд хуульчийн үйл ажиллагааны чиглэлээр менторшип хөтөлбөрт үр дүнтэй оролцсон ментор хуульчид 2 хүртэлх багц цаг тооцох;

6.Тухайн жилд гадаад улсад хууль зүйн чиглэлээр магистр, докторын зэрэг хамгаалсан хуульчийн диплом, гэрчилгээг үндэслэн багц цагийг энэ зүйлийн 4.4, 4.5-д заасны дагуу тооцно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН АСУУДЛААР ХОЛБООНЫ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮРЭН ЭРХ

4.1 дүгээр зүйл.Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах

1.Холбоо үргэлжилсэн сургалттай холбогдсон чиг үүргээ Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороо /цаашид “Сургалтын хороо” гэх/-гоор дамжуулан хэрэгжүүлнэ.

4.2 дугаар зүйл.Холбооны зөвлөлийн бүрэн эрх

1.Холбооны Зөвлөл үргэлжилсэн сургалттай холбоотой асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1.1.Үргэлжилсэн сургалтын талаар Холбооноос баримтлах бодлогыг тодорхойлж, үргэлжилсэн сургалттай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сургалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах;

1.2.Тамгын газар, Сургалтын хороо, тус хороог хариуцсан мэргэжилтний үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах;

1.3.үргэлжилсэн сургалтын хөтөлбөр, зохион байгуулалттай холбоотой эх нотлох баримтын архив болон цахим мэдээллийн санг үүсгэх, хөтлөх, төрөлжүүлэн хадгалах, тэдгээрийн хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх;

1.4.үргэлжилсэн сургалтыг зохион байгуулахад шаардлагатай техник технологи, программ хангамжийн хүчин чадлыг сайжруулах асуудлыг нэгдсэн бодлого, төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх;

1.5.сургалтын зохион байгуулалт, хуульч сургалтад хамрагдсан байдал, хуульчийн багц цагийн нэгдсэн бүртгэлийн хөтлөлт, түүний үнэн зөвийг нягтлах ажлыг зохион байгуулах, илэрсэн дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах замаар үргэлжилсэн сургалтын үр дүн, зорилтыг хангах;

1.6.үргэлжилсэн сургалтын үйл ажиллагааны тайлан мэдээг нэгтгэн гаргуулж, хуулийн дагуу мэдээлэх, үйл ажиллагааны мэдээ, тайланд дүн шинжилгээ, судалгаа хийх ажлын үр дүнг хэлэлцэж, зохих шийдвэрийг цаг алдалгүй гаргаж байх;

1.7.үргэлжилсэн сургалттай холбоотой хууль, Холбооны дүрэмд заасан бусад бүрэн эрх.

4.3 дугаар зүйл.Холбооны Ерөнхийлөгчийн бүрэн эрх

1.Холбооны Ерөнхийлөгч үргэлжилсэн сургалттай холбоотой асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1.1.үргэлжилсэн сургалтыг зохион байгуулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэн ажиллах;

1.2.үргэлжилсэн сургалтын үйл ажиллагаанд хамаарах бичиг баримтын загвар, маягт, холбогдох зааврыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, биелэлтийг хангуулах;

1.3.үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цагийн хангалт тооцох асуудлаар Сургалтын хорооны явуулсан үйл ажиллагаанд хяналт тавьж, хууль тогтоомжид нийцээгүй шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох;

1.4.үргэлжилсэн сургалттай холбоотой хууль, Холбооны дүрэмд заасан бусад бүрэн эрх.

4.4 дүгээр зүйл. Холбооны Тамгын газрын бүрэн эрх

1.Үргэлжилсэн сургалтын бүртгэлтэй холбоотой асуудлаар Тамгын газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1.1.сургалтын хорооны үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэн ажиллах;

1.2.сургалтын хороо хариуцсан мэргэжилтнийг томилж, түүний үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах;

1.3.сургалтын үйл ажиллагаатай холбоотой эх нотлох баримтын архив болон цахим мэдээллийн санг үүсгэх, хөтлөх, төрөлжүүлэн хадгалах, тэдгээрийн хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах;

1.4.сургалтын асуудал хариуцсан боловсон хүчний чадавх, техник технологи, программ хангамжийг бэхжүүлэх, найдвартай ажиллагааг хангах;

1.5. сургалтын нэгдсэн бүртгэлийн үйл ажиллагааны тайлан мэдээг Холбооны хэмжээнд нэгтгэн гаргах, хуулийн дагуу мэдээлэх, үйл ажиллагааны мэдээ, тайланд дүн шинжилгээ, судалгаа хийх;

1.6.сургалт зохион байгуулах асуудлаар сургалтын байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт болон магадлан итгэмжлүүлэхээр ирүүлсэн сургалтын хөтөлбөрийг судалж Сургалтын хороонд танилцуулж, шийдвэрлүүлэх;

1.7. үргэлжилсэн сургалттай холбоотой хууль, Холбооны дүрэмд заасан бусад бүрэн эрх.

4.5 дугаар зүйл.Сургалтын хорооны бүрэн эрх

1.Үргэлжилсэн сургалттай холбоотой асуудлаар Сургалтын хороо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1.1.хуульчдад зориулсан сургалтын бодлого, үндсэн чиглэл, хэлбэрийг тодорхойлох, үргэлжилсэн сургалтыг явуулах аргачлал, арга зүйг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах, баталж мөрдүүлэх;

1.2.чиг үүргийн болон сайн дурын хороо, бусад иргэн, хуулийн этгээдээс үргэлжилсэн сургалтад зориулан боловсруулсан сургалтын хөтөлбөрийг хянаж, магадлан итгэмжлэх;

1.3. тухайн жилд зохион байгуулах үргэлжилсэн сургалтын төлөвлөгөөг боловсруулж, хуульчдад мэдээлэх;

1.4. батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу үргэлжилсэн болон нөхөн сургалтыг улсын хэмжээнд зохион байгуулах;

1.5. үргэлжилсэн сургалт явуулах сургагч багш бэлтгэх, сургалт явуулах багшийг бэлтгэх, сонгон шалгаруулах, давтан сургах ажлыг зохион байгуулах;

1.6. үргэлжилсэн сургалтын холбогдох баримтыг бүрдүүлж, цахим мэдээллийн санг үүсгэн хөтөлж тухайн ондоо багтаан Тамгын газарт өгч байх;

1.7. үргэлжилсэн сургалттай холбогдсон асуудлын хүрээнд сургалтын төрөлжсөн байгууллага, бусад этгээдтэй Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу харилцах, хамтран ажиллах;

1.8. үргэлжилсэн сургалт зохион байгуулж байгаа этгээдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах;

1.9. үргэлжилсэн сургалтын явц, үр дүнгийн талаар дүгнэлт гаргах;

1.10. багц цаг тооцох аргачлалыг тогтоож, хуульчдаас сургалтын багц цагийг хангаж байгаа байдалд хяналт тавих;

1.11. үргэлжилсэн сургалтын багц цагийн хангалтын бүртгэл хөтлөлт, түүний үнэн зөвийг нягтлан бүрдлийг хангах, илэрсэн дутагдлыг арилгах арга хэмжээ авах замаар багц цагийн хангалтын үнэн зөв, бодит байдлыг хангах;

1.12. үргэлжилсэн сургалт, түүний багц цаг хангалттай холбоотой үйл ажиллагааны тайлан мэдээг Холбооны хэмжээнд нэгтгэн гаргах, хуулийн дагуу мэдээлэх, үйл ажиллагааны мэдээ, тайланд дүн шинжилгээ, судалгаа хийх;

1.13. сайн дурын хороодын саналаар Сургалтын дэд хороо байгуулах;

1.14. үргэлжилсэн сургалт, багц цагийн хангалттай холбоотой хууль, Холбооны дүрэм, журамд заасан бусад бүрэн эрх;

1.15. Сургалтын дэд хороодын үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор дэд хорооноос бие даан зохион байгуулсан сургалтын төлбөрийн 20 хувийг тухайн дэд хороонд олгох эсэх асуудлыг шийдвэрлэх;

1.16. Үргэлжилсэн сургалтын төлбөр болон сургагч багшийн ажлын хөлсний талаар санал боловсруулж Холбооны Зөвлөлөөр хэлэлцүүлэх.

4.6 дугаар зүйл. Сургалтын хороо хариуцсан мэргэжилтний бүрэн эрх

1. Үргэлжилсэн сургалттай холбогдсон өдөр тутмын үйл ажиллагааг Сургалтын хороо хариуцсан Тамгын газрын мэргэжилтэн хэрэгжүүлнэ.

2. Сургалтын хороо хариуцсан мэргэжилтнийг Тамгын газрын дарга томилж, түүний өдөр тутмын үйл ажиллагаанд нь хяналт тавина.

3. Сургалтын хороо хариуцсан мэргэжилтэн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3.1. сургалтын хорооны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, Холбоо, сургалтын хорооны болон гишүүд хоорондын үйл ажиллагааг нэгтгэн, харилцан мэдээллээр хангах, тэдгээрийн хоорондын үйл ажиллагааг уялдуулан ажиллах;

3.2. сургалтын хорооны хуралдаан, бусад үйл ажиллагааг зохион байгуулах, хурал явуулах байр, танхимыг бэлтгэх, хурлын ирцийг бүртгэж, танилцуулах, хурлын үйл ажиллагааг тэмдэглэл үйлдэн баталгаажуулах, хурлаас гарсан шийдвэрийг хүргүүлэх, шийдвэрийн талаар холбогдох этгээдэд мэдэгдэх;

3.3.үргэлжилсэн сургалтын төлөвлөгөөнд заасан хугацаанд сургалт зохион байгуулагдаж буй эсэхэд хяналт тавьж ажиллах;

3.4.үргэлжилсэн сургалтын сэдэв, хөтөлбөр багц цагийн хангалттай холбоотой гишүүдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хянан үзэж, эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэх;

3.5.үргэлжилсэн сургалттай холбоотой асуудлаар эрх бүхий этгээдийн гаргасан шийдвэрийг үндэслэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гарган шийдвэрлүүлэх;

3.6.сургалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн санг бүрдүүлэх, тэдгээрт байнгын баяжилт хийх, хадгалах;

3.7.гишүүний гаргасан хүсэлтийн дагуу үргэлжилсэн сургалттай холбоотой мэдээлэл, лавлагааг гарган өгөх;

3.8.үргэлжилсэн сургалт, багц цагийн хангалттай холбоотой асуудлаар хуульчдад мэдээлэл, зөвлөгөө өгөх;

3.9.үргэлжилсэн сургалттай холбоотой хууль, Холбооны дүрэм, журамд заасан бусад бүрэн эрх.

4.7 дугаар зүйл.Сургалтын дэд хороо, түүний чиг үүрэг

1.Үргэлжилсэн сургалтын төлөвлөлт, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, сургалтын чанар, үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор Сургалтын хороо нь дэргэдээ шүүх, прокурор, өмгөөлөгч, бусад хуульчдын сургалтын дэд хороо байгуулан ажиллуулж болно.

2.Сургалтын дэд хороо нь хөтөлбөрөө сургалтын хороогоор магадлан

итгэмжлүүлсний үндсэн дээр бие даан сургалт зохион байгуулах, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, тухайн жилд явагдах сургалтын сэдвийг тодорхойлох, сургалтын үр дүнг үнэлэх, судалгаа хийх болон Сургалтын хорооноос даалгасан бусад ажлыг гүйцэтгэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.Сургалтын дэд хорооны дарга, гишүүнийг тухайн хорооны саналыг үндэслэн 2 жилийн хугацаатайгаар Сургалтын хороо томилно.

4. Шүүгчдийг дадлагажуулах, мэргэшлийг нь дээшлүүлэх 3 хүртэлх багц цагийн сургалтыг Монгол Улсын Дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнтэй хамтран, 1-ээс доошгүй багц цагийн сургалтыг дангаар зохион байгуулна.

5. Прокурорыг дадлагажуулах, мэргэшүүлэх 3 хүртэлх багц цагийн сургалтыг Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, Судалгааны хүрээлэнтэй хамтран, 1-ээс доошгүй багц цагийн сургалтыг дангаар зохион байгуулна.

.ТАВДУГААР БҮЛЭГ ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

5.1 дүгээр зүйл.Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах

1.Үргэлжилсэн сургалтыг батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулах ажлыг Сургалтын хороо гүйцэтгэнэ.

2.Бусад байгууллагаас хуульчийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор сургалт явуулах бол сургалтын хөтөлбөрөө энэ журамд заасны дагуу Сургалтын хороогоор магадлан итгэмжлүүлсний үндсэн дээр зохион байгуулна.

3. Видео болон аудио хэлбэрээр бэлтгэсэн сургалтад тусгайлсан хөтөлбөр шаардахгүй. 4.Энэ зүйлийн 2, 3-т заасны дагуу сургалтын хороогоор магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан сургалтыг үргэлжилсэн сургалтын багц цагийн хангалтад тооцно.

5.2 дугаар зүйл. Хуульчийн үргэлжилсэн сургалтын төлбөр

1.Суурь сургалт, мэргэшүүлэх сургалт, видео болон аудио сургалт нь төлбөртэй байх ба төлбөрийн хэмжээг Сургалтын хорооны саналыг үндэслэн Холбооны зөвлөл тогтооно.

2.Шүүгч, прокурорын сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх ба өмгөөлөгч,бусад хуульчид өөрсдийн зардлаар сургалтад хамрагдана.

3.Энэ журмын 3.1 дүгээр зүйлийн 2, 3-т заасан байгууллагуудад энэ зүйлийн 1 дэх заалт хамаарахгүй.

4.Энэ журмын 3.1 дүгээр зүйлийн 2, 3-т заасан байгууллагууд сургалтыг төлбөртэй болон төлбөргүй зохион байгуулснаас үл хамааран Холбооноос тогтоосон 1 багц цагт ногдох төлбөрийн 20 хувьтай тэнцэх төлбөрийг сургалтад оролцогчдын тоогоор Холбоонд төлнө.

5.Шүүгч, прокурорын сургалтыг сургалт хариуцсан тусгай байгууллага /ШЕЗ, УЕПГ- ын дэргэдэх "Сургалт, судалгааны хүрээлэн" / энэхүү журамд заасны дагуу бие даан зохион байгуулсан тохиолдолд Холбооноос тогтоосон 1 багц цагт ногдох төлбөрийн 20 хувьтай тэнцэх төлбөрийг сургалтад оролцогчдын тоогоор Холбоонд төлнө.

6.Энэ журмын 6.1 дүгээр зүйлийн 4.2-4.10-т заасны дагуу танхимын бус хэлбэрээр багц цаг тооцуулах бол тооцуулах багц цагийн төлбөрийн 20 хувийг, энэ журмын 5.2 дугаар зүйлийн 10-т зааснаар багц цаг тооцуулах бол тооцуулах багц цагийн төлбөрийн 10 хувийг тус тус Холбоонд төлнө.

7.Нөхөн сургалтын багц цагийн сургалтын төлбөр нь үргэлжилсэн сургалтын багц цагийн хэмжээнээс илүү байна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

6.1 дүгээр зүйл.Хуульчийн үргэлжилсэн сургалтын хөтөлбөр

1.Үргэлжилсэн сургалтын нэгдсэн хөтөлбөрийг тухайн хичээлийн жилд шинээр батлагдсан болон батлагдахаар төлөвлөгдөж байгаа хууль тогтоомж, эрх зүйн шинэчлэлийн агуулга, мэдээллийн хэрэгцээ, шаардлага, хуульчдын саналд тулгуурлан Сургалтын хороо жил бүр шинэчлэн батална.

2.Сургалтын хороо үргэлжилсэн сургалтын хөтөлбөр боловсруулах ажлыг хорооны гишүүдээр гүйцэтгүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд сургалтын дэд хороод, сургагч багш нарын дэмжлэгийг авч болно.

3.Сургалтын хороо үргэлжилсэн сургалтын нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөг тухайн хичээлийн жил эхлэхээс өмнө баталж, сургалтыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.

4.Сургалтын нэгдсэн хөтөлбөрт тухайн жилд зохион байгуулах сургалтын үндсэн чиглэлийг эрх зүйн салбараар, нарийвчилсан хөтөлбөрийг хичээлийн сэдэв, агуулгаар тогтоож, сургалт явуулах хэлбэр, хугацааг нарийвчлан тусгана.

6.2 дугаар зүйл.Сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх

1.Үргэлжилсэн сургалтын хөтөлбөрийг Сургалтын хороогоор магадлан итгэмжлүүлсэн байна.

2.Энэ журмын 3.1 дүгээр зүйлийн 3-т заасан этгээдийн зохион байгуулах сургалтын хөтөлбөрийг 2 жил тутамд Сургалтын хороо магадлан итгэмжилнэ.

3.Сургалтын хөтөлбөр нь энэ журмын 1.1 дүгээр зүйлийн 2-т заасан зорилгод нийцсэн, Сургалтын хорооноос баталсан сургалтын хөтөлбөрийн ерөнхий чиглэлийн хүрээнд боловсруулагдсан байна.

4.Сургалтын хөтөлбөр нь энэ журмын хавсралтад заасан жишиг сургалтын хөтөлбөрийн дагуу боловсруулагдсан байна.

5.Магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрөөр явуулсан сургалтад багц цаг тооцох эсэхийг хөтөлбөрийн шаардлага хангасан нотлох баримтад үндэслэн шийдвэрлэнэ.

6.Сургалтын хороо нь хөтөлбөр, гарын авлагын зохиогчтой зөвшилцөн хөтөлбөр, гарын авлагад зарим засвар, нэмэлт өөрчлөлт оруулж болно.

7.Сургалтын хороонд ирүүлсэн сургалтын хөтөлбөр шаардлага хангаагүй бол магадлан итгэмжлэхээс татгалзах, хөтөлбөрөө дахин сайжруулахыг даалгах, сургалтын төлбөрийн хэмжээ тогтоосон үндэслэлээ тодруулахыг шаардах эрхийг Сургалтын хороо эдэлнэ.

8.Сургалтын хорооноос бусад хүн, хуулийн этгээд, байгууллагын зохион байгуулсан сургалт нь тухайн жилийн үргэлжилсэн сургалтын хөтөлбөрийн үндсэн чиглэлд хамаарч байгаа бол тухайн сургалтын агуулга, ач холбогдлыг нь харгалзан Сургалтын хороо үргэлжилсэн сургалтын багц цагт тооцож болно.

9.Энэ зүйлийн 8-д заасан сургалтыг зохион байгуулсан хүн, хуулийн этгээд, байгууллага энэ зүйлийн 5-д заасан хөтөлбөр, 6-д заасан материалаас гадна, тухайн сургалтад хамрагдсан хуульчийн овог нэр, регистерын дугаар, хуульчдын нэгдсэн бүртгэлийн дугаар, сургалтад хамрагдсаныг нотлох баримтыг Сургалтын хороонд хүргүүлсэн байна.

10.Гадаад улсад ижил төстэй сургалтад хамрагдсан хуульч нь тус сургалтад хамрагдахаасаа өмнө эсхүл сургалтад хамрагдсаныхаа дараа тухайн сургалтынхаа хөтөлбөрийг Сургалтын хороогоор хэлэлцүүсний үндсэн дээр сургалт зохион байгуулсан гадаад улсын байгууллагаас ирүүлсэн нотлох баримтыг үндэслэн багц цагт тооцуулж болно.

6.3 дугаар зүйл.Багц цагийн хангалтыг тооцох

1.Үргэлжилсэн сургалтад хамрагдсан, сургалтын бус хэлбэрээр, практикийн бусад сургалтад багц цаг тооцуулах тохиолдолд холбогдох нотлох баримтыг ирүүлнэ.

2.Үргэлжилсэн сургалтын багц цагийг хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгогдсон сараас эхлэн нэг жилд хангах багцын хэмжээнд хувь тэнцүүлэн тооцно.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нотлох баримтыг үндэслэн сургалтын багц цаг тооцох эсэхийг Сургалтын хороо шийдвэрлэнэ.

4.Багц цаг тооцох, бичилт хийх ажиллагааг Сургалтын хороо хариуцсан мэргэжилтэн гүйцэтгэх ба Сургалтын хорооны дарга, гишүүн, Холбооны Тамгын газар хяналт тавина.

5.Багц цагийн тооцоог Сургалтын хорооны шийдвэр болон сургалтын төлбөр төлсөн тухай баримтыг үндэслэн Холбооны албан ёсны цахим хуудас дахь хуульчийн дансанд байршуулж, хуульч өөрийн нууц үгээр нэвтэрч харах боломжоор хангасан байна

6.Сургалтын хороо хуульчийн хүсэлтээр багц цагийн хангалтын талаарх тодорхойлолт олгож болно.

ДОЛДУГААР БҮЛЭГ ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН ТАЙЛАН, БАГЦ ЦАГИЙН МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦОО

7.1 дүгээр зүйл.Сургалтын мэдээлэл, хяналтын тогтолцоо

1.Сургалтын хороо нь үргэлжилсэн сургалт, түүнд хамрагдаж буй хуульчийн талаарх нэгдсэн мэдээллийн санг хөтөлж, цахим мэдээлэл, лавлагааг эрх бүхий байгууллага болон хуульчдад гаргаж өгнө.

2.Хуульч зөвхөн өөрийн багц цагийн талаарх мэдээллийг тусгайлан авсан хувийн нууц дугаарын дагуу цахим хуудсаар дамжуулан шалгах боломжтой байна.

3.Үргэлжилсэн сургалтад хамрагдаж, сургалтын багц цаг хангаснаа нотлох үүргийг хуульч өөрөө хүлээнэ.

4.Магадлан итгэмжлэгдсэн сургалт зохион байгуулсан этгээд нь тухайн сургалтад оролцож багц цаг хангасан хуульчдын нэрсийн жагсаалт, ирцийг сургалт явагдсан тайлангийн хамт сургалт явагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор Сургалтын хороонд ирүүлнэ.

5.Сургалтын хороо тухайн жилийн үргэлжилсэн сургалтын тайланг дараа оны эхний сард багтаан Зөвлөлд танилцуулна. Тайланд үргэлжилсэн сургалт зохион байгуулсан байдал, орлого, зарлага, хамрагдсан хуульчдын тоо, багц цаг хангасан байдлыг тусгасан байна.

6.Үргэлжилсэн сургалттай холбоотой асуудлаарх хяналтыг дор дурдсан байдлаар хэрэгжүүлнэ:

6.1.үргэлжилсэн сургалтын хөтөлбөр боловсруулах, зохион байгуулах, багц цагийг тооцох зэрэг Сургалтын хорооны үйл ажиллагаанд Зөвлөл;

6.2.үргэлжилсэн сургалт зохион байгуулж байгаа байдал, түүний чанар,оролцогчдын бүртгэл, багц цагийн тооцоо зэргийн үнэн зөв байдалд Сургалтын хороо;

6.3.хуульч үргэлжилсэн сургалтад бүрэн хамрагдаж байгаа эсэхэд Сургалтын хороо, тус хороог хариуцсан мэргэжилтэн болон Хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн тус тус хяналт тавина.

7.2 дугаар зүйл. Хуульчийн үргэлжилсэн сургалтын багц цаг хангах үүрэг

1.Хуульч үргэлжилсэн сургалтад хамрагдаж, энэ журмын 5.1 дүгээр зүйлийн 1-д заасан сургалтын багц цагийг хангах үүрэгтэй.

2.Хуульч, гишүүний эрх болон хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө түдгэлзүүлсэн хугацаанд жил бүр 2-оос доошгүй багц цагийн сургалтад заавал хамрагдсан байна.

3.Хуульд заасны дагуу хүүхэд асрах чөлөөтэй, цэргийн алба хааж байгаа хуульчдыг үргэлжилсэн сургалтаас холбогдох нотлох баримтыг үндэслэн чөлөөлнө.

7.3 Хуульчийн үргэлжилсэн сургалтад хамрагдаагүй хуульчид хүлээлгэх хариуцлага

1.Үргэлжилсэн сургалтад хамрагдах үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй нь Хуульчийн мэргэжлийн дүрмийн зөрчил тул уг дүрэмд заасан хариуцлага тооцох үндэслэл болно.

2.Багц цаг хангах үүргээ биелүүлээгүй буюу нэг жилд хангах багц цагийн 50 болон түүнээс дээш хувийг хангаагүй хуульчийг дараагийн жилд нөхөн сургалтад хамрагдах тухай мэдэгдлийг Сургалтын хороо хүргүүлэх бөгөөд нөхөн сургалтыг зөвхөн Сургалтын хороо зохион байгуулна.

3.Энэ зүйлийн 2-т заасан мэдэгдэл хүлээн авсан хуульч нөхөн сургалтад хамрагдахаас татгалзсан, сургалтад хамрагдаагүй тохиолдолд Сургалтын хороо тухайн хуульчийн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүйд тооцуулахаар Мэргэжлийн хариуцлагын хороонд шилжүүлнэ.

7.4 дүгээр зүйл. Хуульчийн үргэлжилсэн сургалттай холбоотой маргааныг хянан шийдвэрлэх

1.Хуульч үргэлжилсэн сургалтын хөтөлбөрийн агуулга, зохион байгуулалт, багц цагийн тооцоо, бичилт, сургалтын чанартай холбоотой асуудлаарх санал, хүсэлт, гомдлоо Сургалтын хороонд гаргана.

2.Санал, хүсэлт, гомдлыг Сургалтын хороо хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор хянан шийдвэрлэж, хариу өгнө.

3.Хуульч Сургалтын хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл, Холбооны Ерөнхийлөгчид гомдол гаргах эрхтэй.

4.Сургалтын хорооны үйл ажиллагаа, шийдвэртэй холбоотой гомдол, хүсэлтийг Сургалтын хороо хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэж хариу өгнө.

5.Энэ зүйлийн 1-д заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор Холбооны Зөвлөлд гомдол гаргах эрхтэй

НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

8.1 дүгээр зүйл. Хуульчийн үргэлжилсэн сургалттай холбоотой хуульчийн эрх

1.Үргэлжилсэн сургалттай холбоотой асуудлаар хуульч дор дурдсан эрх эдэлнэ:

1.1.үргэлжилсэн сургалттай холбоотой асуудлаар Холбоонд санал, хүсэлт, гомдол гарган шийдвэрлүүлэх;

1.2.хүндэтгэн үзэх шалтгааны улмаас тухайн жилийн үргэлжилсэн сургалтад хамрагдах хугацааг хойшлуулах тухай хүсэлт гаргах;

1.3.үргэлжилсэн сургалтын багц цагийн бүртгэл, тооцоотой холбоотой мэдээлэлтэй танилцах, холбогдох лавлагаа, тодорхойлолт гаргуулан авах;

1.4.үргэлжилсэн сургалтын талаарх ташаа мэдээллийг өөрчлөх, засвар оруулахыг шаардах.

8.2 дугаар зүйл. Журам хүчин төгөлдөр болох

1.Энэ журмыг 2023 оны дүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

---000---